

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 392 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

Маягт 1

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэл (2025 он)-ийн санал

Санал болгож байгаа тэргүүлэх чиглэл №1:		Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хангамжийг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх
1.	2.	3.
N°	Шалгуур үзүүлэлтүүд	Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа талаарх тайлбар
1.	Монгол Улсын урт, дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт тодорхойлсон нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдсан байх	Тогтвортой хөгжлийн 17 зорилтоос эрүүл мэндийг дэмжих, баталгаат ажлын байр бий болгох, инновац зэрэг зорилтуудыг хангаж байна. Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.10 дугаар заалт “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу дээрх тэргүүлэх чиглэлийг тодорхойлов.
2.	Үндэсний аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн байх	Онцгой байдлын Ерөнхий газартай байгуулсан нууц гэрээний биелэлт, Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангахад цус, цусан бүтээгдэхүүний байнгын нөөц чухал ач холбогдолтой болно.
3.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр/ салбарын төлөвлөгөөнд туссан тэргүүлэх чиглэлүүдтэй холбоотой зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/-үүдийг байгуулахтай холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэнэ. Үүнтэй уялдуулан цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг автоматжуулах, цус, сийвэн цуглуулах суурин төвүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай.

4.	Хүний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, амьдралын нөхцлийг сайжруулах, хүний хөгжилд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх	Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ 2013 онд 39811 нэгж байсан бол 2023 онд 107377 нэгж болж өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна. Өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах нь цаашдын тулгамдсан асуудлуудын нэг зайлшгүй мөн. Иймээс эрүүл мэндийн хөгжлийн бодлогын хүрээнд сийвэнгийн төвийг байгуулах нь нийгэм эдийн засгийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.
5.	Эруул мэндийн байгууллага/ажилтны тусламж үйлчилгээний чанар/мэдлэг чадавхийг сайжруулж, үйлчлүүлэгчийн гадагш/төв рүү чиглэсэн урсгалыг бууруулах болон эруул мэндийн аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн байх	ДЭМБ-ын зөвлөмжөөр 1 саяас дээш хүн амтай хотод 6-8 цус цуглуулах төв ажилласан үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц хүрэлцээтэй, хэрэгцээ хангагдана гэж үздэг. Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь Улаанбаатар хотын хэмжээнд алслагдсан 2 дүүргийг оролцуулан нийт цус цуглуулах 5 суурин төв, орон нутагт 21 аймаг, 3 суманд нийт 24 Цусны салбар төв (ЦСТ) байгаа бөгөөд улсын хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ)-ий нөөц, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. ЦССҮТ нь ЦЦБ-ийг рентген туяагаар шарах технологи, улаан эсийг хөлдөөж хадгалах технологи, бүтээгдэхүүний эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэх технологи зэрэг орчин үеийн шинэ технологийг үйл ажиллагаандаа нутагшуулсантай холбоотойгоор цаашид цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүн, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэлд эзлэх хувийг нэмэгдүүлэн ажиллахыг зорьж байна. Бүхэл цус үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулснаар ажлын урсгал оновчтой болж, гар ажиллагаа, шат дамжлага багасан, цаг хугацаа хэмнэж, хүнээс шалтгаалсан алдаа гарахаас сэргийлэх, үйлдвэрт тэнцэхгүй бүтээгдэхүүн тоог бууруулах боломжтой болно. Цус цуглуулах төвийн тоог нэмэгдүүлснээр өсөн нэмэгдэж буй цус, цусан бүтээгдэхүүний захиалга хэрэглээг тэгш хүртээмжтэй хангах, цусны донор, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломжтой болно.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 392 тоот албан бичгийн 2 дугаар хавсралт

Маягт 2

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэл (2025 он)-ийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал

Санал болгож байгаа төсөл, арга хэмжээ:		1. Бүхэл цусыг боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ (Reveos® Automated Blood Processing System)-ыг нэвтрүүлж, нутагшуулах 2. Сонгинохайрхан дүүрэгт Цус цуглуулах суурин төв шинээр байгуулах 3. Аферезийн төв байгуулах
Аль тэргүүлэх чиглэлд хамаарах:		Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хангамжийг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх
Төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулах үндэслэл		
№	Шалгуур үзүүлэлтүүд	Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа талаарх тайлбар
1.	2.	3.
1.	Үндсэн зориулалт, хамрах хүрээ, салбарын асуудлыг шийдвэрлэх байдал	Бүхэл цус үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулснаар ажлын урсгал оновчтой болж, гар ажиллагаа, шат дамжлага багасан, цаг хугацаа хэмнэж, хүнээс шалтгаалсан алдаа гарахаас сэргийлэх, үйлдвэрт тэнцэхгүй бүтээгдэхүүн тоог бууруулах боломжтой болно. Цус цуглуулах төвийн тоог нэмэгдүүлснээр өсөн нэмэгдэж буй цус, цусан бүтээгдэхүүний захиалга хэрэглээг тэгш хүртээмжтэй хангах, цусны донор, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломжтой болно. Сийвэнгийн бүтээгдэхүүний хэрэглээ 2012 онд 17108 нэгж байсан бол 2023 онд 24991 нэгж болж өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна. Өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах нь цаашдын тулгамдсан асуудлуудын нэг зайлшгүй мөн. Иймээс эрүүл мэндийн хөгжлийн бодлогын хүрээнд сийвэнгийн төвийг байгуулах нь нийгэм эдийн засгийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Эрүүл мэндийн салбарт нэвтрүүлж, нутагшуулж байгаа дэвшилтэт шинэ технологиудтай холбоотойгоор цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байна. Үүнтэй уялдуулан цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг боловсронгуй болгох, цус цуглуулах төвүүдийг нэмэгдүүлснээр эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.	Монгол Улсад болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эмнэлзүйн аюулгүй байдлыг хангасан, эдийн засгийн үр өгөөж бүхий өндөр технологи байх	Бүхэл цусыг боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ (Reveos® Automated Blood Processing System) технологи нь дэлхийн 20 орны 100 гаруй Цусны албанд нэвтэрсэн, эмнэлзүйн аюулгүй байдлыг хангасан, эдийн засгийн үр өгөөж бүхий өндөр технологи юм.
3.	Өмнө хийгдсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын талаарх мэдээлэл, хэрэглээнд нэвтрүүлсэн шинэ технологи байх, 2024 оны суурь түвшин	АНУ-ын Хүнс, эмийн агентлаг(FDA)-ийн хийсэн судалгаагаар эмнэлзүйн гүйцэтгэлд үндэслэн бүхэл цусыг боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ /Reveos® Automated Blood Processing System/ нь хүлээгдэж буй байдлаар ажиллаж, аюулгүй байдлаар ажилласан 42 хоногийн хадгалалтын дараа 24 цагийн турш сэргэх шалгуурыг хангасан.
4.	Тухайн технологийг нутагшуулах, хөгжүүлэхэд шаардагдах хугацаа	2025-2028 он
5.	Монгол улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэсэн байх	Монгол улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх шинэ технологи нэвтрүүлж нутагшуулахад шаардлагатай цус цусан бүтээгдэхүүн, био бэлдмэлийн тэгш хүртээмжтэй байдлыг хангагдана.
6.	Нийгэм, эдийн засагт үзүүлэх бодит үр өгөөж	Монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, амь насыг аврах, гадагшаа чиглэсэн валютын урсгалыг сааруулах эерэг нөлөөлөл үзүүлнэ.